



123

ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 4/50

Шивээговь сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны өрөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ НЬ:**

1.Сумын 2 дугаар багийн иргэн Эрдэнэцогтын Уужим нь тархины ясны өвчний улмаас Турк улсад хагалгаанд орох шаардлагатай болсон тул хагалгааны зардалд хандивлаж 300,000 (гурван зуун мянга) төгрөгийг зарцуулсугай.

2.Хагалгааны зардлын хандивт зарцуулагдах 300,000 (гурван зуун мянга) төгрөгийг хууль журмын дагуу баримт бичгийн бүрдлийг хангаж, Засаг даргын нөөц хөрөнгөөс зохих журмын дагуу гаргахыг нягтлан бодогч (Д.Сэлэнгээ)-д зөвшөөрсүгэй.

3.Холбогдох ажлыг зохион байгуулж, анхан шатны баримт бичгийн бүрдлийг хангаж ажиллахыг Нийгмийн бодлогын мэргэжилтэн (Б.Алтансүх)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ч.Сугармаа)-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА *П.ГАНЧИМЭГ* П.ГАНЧИМЭГ



42123 154